



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (146)

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэртэй тэмцэх материаллаг баазыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай
- “Хүүхдийн хөгжлийг дэмжих жил” зарлах тухай
- Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай
- Тусгай зориулалтаар агнах ховор ан амьтны нэр, тоог тогтоох тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны гуравдугаар сарын 10

№9 (146)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

116.	Дүрэм батлах тухай	Дугаар 215	189
117.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 216	192
118.	Улсын эталон батлах тухай	Дугаар 217	193
119.	Тусгай татвар ногдуулах тухай	Дугаар 218	193
120.	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэртэй тэмцэх материаллаг баазыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 219	193
121.	Дүрэм батлах тухай	Дугаар 220	195
122.	Татварын албаны талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 222	196
123.	"Хүүхдийн хөгжлийг дэмжих жил" зарлах тухай	Дугаар 223	197
124.	Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 224	197
125.	Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 225	201
126.	Тусгай зориулалтаар агнах ховор ан амьтны нэр, тоог тогтоох тухай	Дугаар 226	201

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

127.	Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар	Дугаар 01	201
------	--	-----------	-----

Гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

128.	МАХН-ын архивын баримтыг ашиглуулах журам батлах тухай (Хууль зүйн сайдын 2000-1-12-ны тушаал)	Дугаар 18	203
129.	Журам батлах тухай (Байгаль орчны сайд, сангийн сайдын 1999-12-10-ны тушаал)	Дугаар 154/201	206

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр	Дугаар 215	Улаанбаатар хот
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:	хавсралтын ёсоор баталсугай.	Дүрэм батлах тухай
"Цацрагийн улсын хяналтын дүрэм"-ийг	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ГЭГЭЭРЛИЙН САЙД	Р.АМАРЖАРГАЛ А.БАТТӨР



ЦАЦРАГИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Цацрагийн улсын хяналтын зорилт нь цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн бусад үүсгүүр (цаашид "цацрагийн үүсгүүр" гэнэ)-ийн үйлчлэлээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, цацрагийн ослын шалтгааныг тогтооход чиглэсэн төрийн захиргааны мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх замаар цацрагийн аюулгүй байдлыг хангахад оршино.

2. Цацрагийн улсын хяналтыг Цөмийн энергийн комиссын Цацрагийн хяналтын алба болон цацрагийн хяналтын улсын байцаагч нар хэрэгжүүлнэ. Шаардлагатай бол зарим яам, тусгай газар, орон нутаг, байгууллага, аж ахуйн нэгжид цацрагийн хяналтын байцаагчийг ажиллуулж болно.

3. Цацрагийн хяналтын албаны дарга нь цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

4. Цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор Гэгээрлийн сайд бөгөөд Цөмийн энергийн комиссын дарга томилж, чөлөөлнө.

5. Цацрагийн хяналтын улсын байцаагч нар (цаашид байцаагч гэх) нь цацрагийн хяналтын чиглэлээр мэргэшсэн, энэ чиглэлээр зохих түвшний шалгалт өгч тэнцсэн хүмүүс байна.

6. Цацрагийн хяналтын алба, байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

7. Цацрагийн хяналтын алба, байцаагчид нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, акт, зөрчлийн тухай протокол, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЁР. Цацрагийн улсын хяналтын үндсэн чиглэл

8. Цацрагийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/цацрагийн хамгаалалт, аюулгүй

байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, заавар, цацрагийн аюулгүйн норм, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;

б/цацрагийн аюулгүй байдалтай холбогдсон олон улсын конвенц, гэрээ, эрх зүйн бусад актуудын биелэлтийг хянах;

в/цацрагийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн баримт бичиг, цацрагийн аюулгүйн норм болон цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, хадгалах, хамгаалах, буулгах, тээвэрлэх, мэдээлэх, бүртгэх, хянахтай холбогдсон асуудлыг зохицуулах дүрмийг боловсруулж гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

г/цацрагийн үүсгүүрийг олборлох, боловсруулах, дахин боловсруулах, төсөл зохиох, үйлдвэрлэх, угсрах, цуглуулах, олж авах, импортлох, экспортлох, хуваарилах, худалдах, эзэлдэх, түрээслэх, хүлээн авах, захиалах, байрлуулах, ашиглалтад оруулах, эзэмшилдээ байлгах, хэрэглэх, ашиглалтад байлгах, засвар үйлчилгээний болон шилжүүлэх шатанд байлгах, ашиглалтаас гаргах, задлах, тээвэрлэх, хадгалах, хоргуйжүүлэх, булшлах зөвшөөрлийг иргэн, аж ахуйн нэгж, байгуулагад холбогдох хууль, дүрэмд заасны дагуу олгох;

д/цацрагийн үүсгүүртэй ажиллах болон түүнийг байрлуулах байгууллага, аж ахуйн нэгжийг барьж байгуулах ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн болон технологийн зураг төслийг зохиох, газар сонгох, тэдгээрийг барьж байгуулах, ашиглалтад оруулахад мөрдөх цацрагийн аюулгүйн норм, дүрмийн биелэлтэд хяналт тавих;

е/цацрагийн үүсгүүр ашигладаг байгууллага, аж ахуйн нэгжийн технологийн ажиллагаа болон түүхий эд, бүтээгдэхүүн, орчны дээж, ундны болон ахуйн хэрэглээний ус, хүнсний зүйл зэргийн цацрагийн бохирдлыг байнга хянаж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэж байгаа эсэхийг хянах, тэдгээрийн аюулгүй байдлын баталгаажилтыг хангах, төрийн захиргааны холбогдох бусад мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтарч зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

ж/цөмийн болон цацрагийн осол, байгаль орчны цацрагийн бохирдолт, нөлөөллөөс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг



нөлөөг илрүүлэх, арилгах арга хэмжээг авах;

з/цацрагийн ослын үүссэн нөхцөл, шалтгааныг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах дүрэм, журам, улсын хэмжээнд авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хянах;

и/улсын хилээр нэвтрүүлэх цацрагийн үүсгүүр бүхий бараа материал, тээврийн хэрэгслийн цацрагийн аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөл олгох;

к/цацрагийн үүсгүүр хэрэглэгч байгууллага, аж ахуйн нэгжид ажиллаж байгаа цацрагийн хяналтын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх;

л/цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

м/байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээний орчны цацрагийн хяналтын цэг, сүлжээг арга зүйн удирдлагаар хангах, багаж төхөөрөмжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх;

н/цацрагийн үүсгүүртэй ажиллагсдын авч байгаа шарлагын тунд хяналт тавьж, нэгдсэн бүртгэл хөтлөх;

о/цацрагийн үүсгүүртэй ажиллагсдын мэдлэг, дадлагыг дээшлүүлэх сургалт, семинар зохион явуулах.

ГУРАВ.Цацрагийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

9.Байцаагч нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдон гарсан тогтоол, шийдвэр, цацрагийн аюулгүйн норм, дүрэм, заавар, журмын биелэлтэд хяналт тавих, түүнийг цаашид боловсронгуй болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, олон нийтэд сурталчлах;

б/цацрагийн үүсгүүрийг улсын бүртгэлд бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлийн үнэн зөв байдалд хяналт тавьж, байнга шинэчлэх;

в/цацрагтай холбогдсон практик үйл ажиллагаа явуулах хүсэлтийн тухай өргөдлийг хянаж, зөвшөөрөл олгох;

г/цацрагтай холбогдсон үйл ажиллагаанд цацрагийн аюулгүй ажиллагаа-дозиметрийн хяналт хийж, дүгнэлт гаргах, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах арга хэмжээ авах, хяналтын үр дүнг мэдээлэх, сурталчлах;

д/цацрагтай холбогдсон үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд шууд буюу шууд бус замаар үүсэж болох сөрөг нөлөөллийг илрүүлж, шалтгааныг тогтоож, энэ асуудлыг эрхэлсэн бусад мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

е/гадаад орчин, хүнсний бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа цацрагаар бохирдсон тохиолдолд хүний эрүүл мэндэд учруулах хор холбогдлын хэмжээг тогтоох, тархалтын шалтгааныг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг бусад мэргэжлийн хяналтын албадтай хамтран зохион байгуулах, хяналт тавих;

ж/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд акт, албан шаардлага бичиж хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулах.

10. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/цацрагийн хяналтын асуудлаар байгууллага, аж ахуйн нэгжид саадгүй нэвтэрч, хяналт шалгалт хийх;



б/цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын үндсэн шаардлагуудыг хангаагүй болон зөрчил дутагдал гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн цацрагтай холбогдсон үйл ажиллагааг түр буюу бүрэн зогсоох;

в/тогтоогдсон норм хэмжээнээс их цацрагийн бохирдолтой хүнсний бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний барааг импортлох, экспортлох, худалдаалж хэрэглэхийг хориглох, устгах, хууль бусаар олсон ашгийг улсын орлогод оруулах, нөхөн төлбөр гаргуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

г/Монгол улсын нутаг дэвсгэрт цацрагийн бохирдол бий болсон үед шаардлагатай бол хилийн боомт, аймаг, нийслэл, сум, дүүрэгт иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатуулах болон бусад арга хэмжээг авах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

д/маргаантай буюу шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр шинжээчийн хэсэг томилох, холбогдох лабораториудаар хяналт, шинжилгээ хийлгэх, магадалгаа, дүгнэлт гаргуулах;

е/цацрагийн хяналт шалгалттай холбогдсон мэдээ судалгаа, тайлбар, тодорхойлолт, баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулж авах;

ж/энэ дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх.

11.Байцаагч нь гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

ДӨРӨВ.Бусад зүйл

12.Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан цацрагийн хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

13.Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан, иргэн нь байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо Хяналтын албаны даргад тавьж шийдвэрлүүлнэ. Албан тушаалтан гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

14.Байцаагч нь үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй болон хууль тогтоомж зөрчвөл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Гэгээрлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Архангай, Төв аймгийн Засаг даргын саналыг үндэслэн нэр бүхий төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнүүдийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Кино урлагийн дээд сургуулийг Монгол Улсын Ардын жүжигчин, төрийн шагналт кино найруулагч Дэжидийн Жигжидийн; Халдвартын клиникийн нэгдсэн эмнэлгийг Монгол Улсын хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хүний гавьяат эмч Вандан-очирын Гаамаагийн;

Архангай аймгийн Ихтамир сумын Хан-өндөрийн бага сургуулийг Монгол Улсын анхны маршал Гэлэгдоржийн Дэмидийн; Төв аймгийн Угтаалцайдам сумын төрөлжсөн сургалттай "Мянгат" сургуулийг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Бэгзийн Батчулууны нэрэмжит тус тус болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

ГЭГЭЭРЛИЙН САЙД

А.БАТТӨР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Улсын эталон батлах тухай

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын засгийн газраас ТОГТООХ нь:

багтаамжтай эталоныг эзэлхүүний нэгжийн улсын эталоноор баталсугай.

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвд хадгалагдаж байгаа 1, 2, 5, 10 ба 50 литрийн

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р. АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД

Я. ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Тусгай татвар ногдуулах тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тутмаас 6000 төгрөгийн тусгай татвар ногдуулсугай.

Монгол Улсаас экспортод гаргах "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн 4103.10.00, 4301.80.12 кодоод хамрагдах ямаа, ишигний боловсруулаагүй арьсанд ширхэг

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р. АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД

Я. ОЧИРСҮХ

ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ч.СОДНОМЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэртэй тэмцэх материаллаг баазыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

шаардагдах ус шүршигч, цуравадагч аппарат, моторт хөрөө, усны сав, чиргүүл зэрэг бусад багаж хэрэгслийг худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг 2001 оны улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэхийг Сангийн сайд Я.Очирсүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

1."Сум, дүүргийн нутаг дэвсгэрт байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэртэй тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслийн жагсаалт"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

4.Энэ тогтоолоор батлагдсан хавсралтын дагуу ой, хээрийн түймэртэй тэмцэх багаж хэрэгслээр хангах, тэдгээрийг эзэмших сургалтыг зохион байгуулах, зориулалтаар нь ашиглуулах арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Д.Ганболд, Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж, Байгаль орчны сайд С.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2.Ой, хээрийн түймрийн мэдээлэл дамжуулах холбооны хэрэгсэл, түймэр унтраах үлээгч аппарат худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг Япон Улс, БНХАУ болон бусад орноос Монгол Улсад үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Н.Туяа, Сангийн сайд Я.Очирсүх, Байгаль орчны сайд С.Мэндсайхан, Хууль зүйн сайд Д.Ганболд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р. АМАРЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

С.МЭНДСАЙХАН

3.Ой, хээрийн түймэр унтраахад

СУМ, ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙГАЛИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХЭД ЗАЙЛШҮЙ ШААРДЛАГАТАЙ БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, нийслэлийн нэр	Түймэр гардаг сум, дүүрэг, тосгоны тоо	Шаардагдах багаж хэрэгсэл							Моторг хөрөө	Цирвадлагч аппарат	Чиргүүл
			Холбооны хэрэгсэл	Үлээгч аппарат	Ус шүршигч	Усны сав /1500 л- эс доошгүй багтаамжтай/	Цуралдагч аппарат					
1	Архангай	17	17	34	102	17	34	17	34	17	-	
2	Сэлэнгэ	20	20	40	120	40	20	20	40	20	-	
3	Булган	12	12	24	72	24	12	12	24	12	-	
4	Хөвсгөл	20	20	40	120	40	20	20	40	20	-	
5	Орхон	2	2	4	12	4	2	2	4	2	-	
6	Дархан-уул	2	2	4	12	4	2	2	4	2	-	
7	Увс	6	6	12	36	12	6	6	12	6	-	
8	Ховд	2	2	4	12	4	2	2	4	2	-	
9	Баян-өлгий	3	3	6	18	6	3	3	6	3	-	
10	Улаанбаатар	9	9	18	54	18	9	9	18	9	-	
11	Завхан	10	10	20	60	20	10	10	20	10	-	
12	Төв	10/4	14	36	84	18	18	18	328	10	4	
13	Өвөрхангай	4/4	8	24	48	12	12	12	16	4	4	
14	Дорнод	5/10	15	50	90	25	25	25	30	5	10	
15	Хэнтий	7/8	15	46	90	23	23	23	30	7	8	
16	Сүхбаатар	13	13	52	78	26	26	26	26	-	13	
17	Говьсүмбэр	2	2	8	12	4	4	4	4	-	2	
	Бүгд	170	170	422	1020	211	211	211	340	129	41	

Тайлбар: Төв, Өвөрхангай, Дорнод, Хэнтий зэрэг аймгийн сумдаг
ойт хээрийн, хээрийн бүсийн гэж 2 ангилсан болно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Патентын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13, 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ийг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

"Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм"-

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Д.ГАНБОЛД

Засгийн газрын 1999 оны 220 дугаар тогтоолын хавсралт

ОЮУНЫ ӨМЧИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Оюуны өмчийн улсын хяналтын зорилго нь Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол оюуны өмчийн байгууллагаас иргэд, өмчийн бүх хэлбэрийн, хамтын болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд оюуны өмчийн талаархи хуулиудын хэрэгжилтийг хангах, хяналт тавихад оршино.

хэлэлцээр, эрх зүйн бусад баримт бичгийн биелэлтийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагаанд шалгах;

б/оюуны өмчийн талаархи хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.

2.Оюуны өмчийн улсын хяналтыг оюуны өмчийн улсын байцаагч (цаашид "байцаагч" гэх) хэрэгжүүлнэ.

Гурав.Оюуны өмчийн улсын хяналтын байцаагчийн үүрэг, эрх

3.Оюуны өмчийн газрын дарга нь оюуны өмчийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

8.Байцаагч нь дараахь үүрэг хүлээнэ:

4.Оюуны өмчийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг оюуны өмчийн ерөнхий байцаагчийн санал болгосноор Хууль зүйн сайд томилж, чөлөөлнө.

а/оюуны өмчийн хууль тогтоомжийн дагуу байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагаанд оюуны өмчийн улсын хяналтыг хэрэгжүүлж, оюуны өмчийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, илэрсэн зөрчлийг шуурхай арилгах арга хэмжээ авах, хяналтын үр дүнг мэдээлэх, сурталчлах;

5.Оюуны өмчийн улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Иргэний хууль, Патентын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

б/оюуны өмчийн эрхэд хохирол учруулсан гэж тодорхойлогдсон үйлдвэрлэл, үйлчилгээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоож, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

6.Оюуны өмчийн улсын ерөнхий болон ахлах байцаагч, улсын байцаагчид нь Хууль зүйн сайдын баталсан загварын үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, мэдэгдэл, албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

в/эрчил, дутагдлын шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэл, бодлогын төслийг боловсруулж холбогдох газарт оруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

Хоёр. Оюуны өмчийн улсын хяналтын чиглэл

г/хяналт шалгалтын явцад

7.Оюуны өмчийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/Монгол Улсын нэгдэн орсон оюуны өмчийн талаархи олон улсын гэрээ, конвенц,

илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд акт, мэдэгдэл бичиж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;



д/хуурамчаар үйлдвэрлэсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэх.

өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэх.

9.Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/хяналт шалгалтын ажилд шаардлагатай бичиг, баримт, мэдээ, судалгаа тодорхойлолтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулж авах;

б/үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ажлын байр, талбайд нэвтрэн орох;

в/байгууллагын удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр хяналт шалгалтын ажилд зохих мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, шинжээчийг томилон ажиллуулах;

г/шаардлагатай гэж үзвэл шалгалтын материалыг хуулийн холбогдох байгууллагад шилжүүлэх;

д/оюуны өмчийн эрх зөрчсөн үйлдлийг зогсоох, эрх зөрчсөн бараа, бүтээгдэхүүн, хууль бус орлогыг хураан авч улсын орлого болгох буюу эрх эзэмшигчид олгох, эсвэл акт үйлдэж устгах арга хэмжээ авах;

е/хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгах талаар

Дөрөв.Бусад зүйл

10.Оюуны өмчийн улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд тогтоосон хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

11.Байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар байцаагчийг хяналт шалгалтад оролцуулбал унаа, байр болон холбогдох бусад зардлыг уг байгууллага нь хариуцна.

12.Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор ерөнхий байцаагчид гаргаж болно. Ерөнхий байцаагч гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж, байцаагчийн шийдвэрийг хүчингүй болгох буюу хэвээр үлдээх тухай шийдвэр гаргаж, энэ тухайгаа гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь байцаагчийн шийдвэрийг биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

13.Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанаас төсөвт орсон орлогын 20 хувь болон хууль тогтоомжид заасан бусад хөрөнгийн эх үүсвэрээс сан байгуулж татварын албаны материаллаг баазыг бэхжүүлэх, тус албаны боловсон хүчний боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх болон тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд сангийн хөрөнгийг зарцуулж байхыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

2.Санг бүрдүүлэх, захиран зарцуулах

Татварын албаны талаар авах зарим арга хэмжээний тухай

журмыг 2000 оны 1 дүгээр сард багтаан баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүхэд үүрэг болгосугай.

3.Татварын хууль тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах нэвтрүүлэг болон орлогоо нуусан буюу татвар төлөхөөс зайлсхийсэн, тогтоосон журмын дагуу орлого, татвараа тодорхойлж тооцоо хийгээгүй татвар төлөгчидтэй хийх тэмцлийг хүчтэй болгоход чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг радио, телевизээр үнэ төлбөргүй нэвтрүүлж байхыг Монголын радио, Монгол телевизийн удирдлагад



үүрэг болгосугай.

урамшил олгох журам"-ыг баримтлахгүй байхаар тогтоосугай.

4.Татварын улсын байцаагчдыг ажлын үр дүнгээр шагнаж урамшуулахад Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

"Хүүхдийн хөгжлийг дэмжих жил" зарлах тухай

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

талын дэмжлэг үзүүлэх зорилгоор 2000 оныг "Хүүхдийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

ГЭГЭЭРЛИЙН САЙД

А.БАТТӨР

Хүүхэд, өсвөр үеийнхний оюун ухаан, авьяас чадварыг хөгжүүлэхэд төрөөс бүх

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

1.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын газар болон Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралтын, Төрийн тусгай албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтын, Төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталж, 2000 оны 1 дүгээр

2.Төрийн үйлчилгээний албаны албан хаагчдын цалингийн санг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 25 хувиар нэмэгдүүлсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

С.СОНИН

Засгийн газрын 1999 оны 224 дүгээр
 тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/саяд таврагаар/

Цалингийн сүлжээний шигшэл	Албан тушаалын зэрэглэл																									
	T3-1	T3-2	T3-3	T3-4	T3-5	T3-6	T3-7	T3-8	T3-9	T3-10	T3-11	T3-12	T3-13	T3-1	T3-2	T3-3	T3-4	T3-5	T3-6	T3-7	T3-8	T3-9	T3-10	T3-11	T3-12	T3-13
1	32144	34649	37153	39658	42580	45501	48425	51346	54269	57190	60321	63661	67210	32144	34649	37153	39658	42580	45501	48425	51346	54269	57190	60321	63661	67210
2	32666	35170	37675	40180	43103	46024	49050	52181	55104	58025	61260	64705	68254	32666	35170	37675	40180	43103	46024	49050	52181	55104	58025	61260	64705	68254
3	33188	35796	38196	40701	43624	46545	49676	53016	55938	58861	62200	65749	69298	33188	35796	38196	40701	43624	46545	49676	53016	55938	58861	62200	65749	69298
4	33814	36423	38719	41224	44146	46964	50303	53850	56774	59696	63140	66896	70445	33814	36423	38719	41224	44146	46964	50303	53850	56774	59696	63140	66896	70445
5	34440	37153	39240	41745	44668	47694	50929	54791	57713	60635	64079	68045	71593	34440	37153	39240	41745	44668	47694	50929	54791	57713	60635	64079	68045	71593
6	35170	37675	39866	42371	45294	48320	51660	55730	58653	61574	65123	69298	72845	35170	37675	39866	42371	45294	48320	51660	55730	58653	61574	65123	69298	72845
7	35901	38405	40493	42998	45920	48946	52390	56669	59591	62513	66166	70549	74098	35901	38405	40493	42998	45920	48946	52390	56669	59591	62513	66166	70549	74098
8	36528	39033	41120	43624	46545	49573	53120	57504	60321	63453	67210	71801	75245	36528	39033	41120	43624	46545	49573	53120	57504	60321	63453	67210	71801	75245
9	37153	39658	41745	44250	47173	50303	53850	58339	61260	64496	68359	72949	76394	37153	39658	41745	44250	47173	50303	53850	58339	61260	64496	68359	72949	76394
10	37780	40180	42371	44668	47903	51138	54686	59174	62200	65540	69505	74098	77438	37780	40180	42371	44668	47903	51138	54686	59174	62200	65540	69505	74098	77438
11	38405	40806	42998	45501	48633	51973	55521	60009	63244	66583	70549	75141	78481	38405	40806	42998	45501	48633	51973	55521	60009	63244	66583	70549	75141	78481
12	38928	41431	43728	46338	49364	53225	56356	60844	64286	67626	71593	76185	79525	38928	41431	43728	46338	49364	53225	56356	60844	64286	67626	71593	76185	79525
13	39449	42059	44458	47173	50199	54060	57400	61679	65228	68566	72533	77229	-	39449	42059	44458	47173	50199	54060	57400	61679	65228	68566	72533	77229	-
14	40076	42684	45294	48006	51034	54791	58443	62513	66166	69505	73471	78273	-	40076	42684	45294	48006	51034	54791	58443	62513	66166	69505	73471	78273	-
15	40701	43311	46129	48738	51868	55521	59486	63348	67105	70445	74411	-	-	40701	43311	46129	48738	51868	55521	59486	63348	67105	70445	74411	-	-
16	41224	43936	46964	49469	52704	56251	60321	64184	68045	71280	75350	-	-	41224	43936	46964	49469	52704	56251	60321	64184	68045	71280	75350	-	-
17	41640	44563	47694	50199	53434	56879	61156	64914	68879	72115	-	-	-	41640	44563	47694	50199	53434	56879	61156	64914	68879	72115	-	-	-
18	42059	45190	48425	50929	54164	57504	61993	65644	69714	72949	-	-	-	42059	45190	48425	50929	54164	57504	61993	65644	69714	72949	-	-	-
19	42475	45710	49155	51556	54894	58130	62723	66166	70549	-	-	-	-	42475	45710	49155	51556	54894	58130	62723	66166	70549	-	-	-	-
20	42789	46233	49780	52181	55521	58653	63348	66896	71385	-	-	-	-	42789	46233	49780	52181	55521	58653	63348	66896	71385	-	-	-	-
21	-	46754	50303	52704	56146	59174	63975	-	-	-	-	-	-	-	46754	50303	52704	56146	59174	63975	-	-	-	-	-	-
22	-	47173	50720	53225	56774	59696	64600	-	-	-	-	-	-	-	47173	50720	53225	56774	59696	64600	-	-	-	-	-	-
23	-	-	51138	53643	57295	60216	-	-	-	-	-	-	-	-	-	51138	53643	57295	60216	-	-	-	-	-	-	-
24	-	-	-	54060	57818	60635	-	-	-	-	-	-	-	-	-	-	54060	57818	60635	-	-	-	-	-	-	-
25	-	-	-	54686	58339	61053	-	-	-	-	-	-	-	-	-	-	54686	58339	61053	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1999 оны 224 дугаар
 тогтоолын 2 дугаар хавсгалт

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/саяд төгрөгөөр/

Цалингийн сүлжээний шугал	Албан тушаалын зэрэглэл										AA-1	
	AA-11	AA-10	AA-9	AA-8	AA-7	AA-6	AA-5	AA-4	AA-3	AA-2		
1	40284	42580	45501	48425	51346	54269	57190	60321	63661	67001	70341	73750
2	40910	43103	46024	49050	52181	55104	58025	61260	64600	68045	71489	72636
3	41640	43624	46545	49676	53016	55938	58861	62200	65540	69089	72636	73750
4	42475	44146	46964	50303	53850	56774	59696	63140	66479	70133	73750	75141
5	43414	44668	47694	50929	54791	57713	60635	64079	67418	71280	75141	76394
6	44355	45294	48320	51660	55730	58653	61574	65123	68566	72429	76394	77646
7	45190	45920	48946	52390	56669	59591	62513	66166	69610	73680	77646	78898
8	46024	46545	49573	53120	57504	60321	63453	67210	70549	74933	78898	80150
9	46859	47173	50303	53850	58339	61260	64496	68359	71489	76185	80150	81403
10	47694	47903	51138	54686	59174	62200	65540	69505	72429	77438	81403	82655
11	48529	48633	51973	55521	60009	63244	66583	70549	73368	78481	82655	-
12	49260	49364	53225	56356	60844	64286	67626	71593	74306	79525	-	-
13	49990	50199	54060	57400	61679	65228	68566	72533	75245	-	-	-
14	50720	51034	54791	58443	62513	66166	69505	73471	76185	-	-	-
15	51346	51868	55521	59486	63348	67105	70445	74411	-	-	-	-
16	51973	52704	56251	60321	64184	68045	71280	75350	-	-	-	-
17	52599	53434	56879	61156	64914	68879	72115	-	-	-	-	-
18	53225	54164	57504	61993	65644	69714	72949	-	-	-	-	-
19	53850	54894	58130	62723	66166	70549	-	-	-	-	-	-
20	54373	55521	58653	63348	66896	71385	-	-	-	-	-	-
21	54894	56146	59174	63975	-	-	-	-	-	-	-	-
22	55313	56774	59696	64600	-	-	-	-	-	-	-	-
23	-	57295	60216	-	-	-	-	-	-	-	-	-
24	-	57818	60635	-	-	-	-	-	-	-	-	-
25	-	58339	61053	-	-	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1999 оны 224 дүгээр тогтоолын 3 дугаар хавсгалд

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/саяд мянрагаар/

Цалингийн сүлжээний төрөл	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	29640	32144	34649	37153	38824	39658	41120	42580	45501	46338	47381	48425	51346	54289	57190	60321	63661	67210
2	30474	32978	35693	39449	41120	41745	43206	44668	47173	48216	49260	50303	53434	56565	59486	62826	65958	69714
3	31518	34021	36945	41745	43414	44041	45710	47381	49050	50720	51556	52599	55730	59069	61574	65330	68461	72219
4	32561	34858	37989	44041	45710	46129	48216	49885	51138	52599	53850	54686	58025	61365	63661	67836	70966	74723
5	33396	35901	39240	46338	48006	48425	49885	52181	52808	54478	55938	56774	60321	63870	65749	70341	73471	77229
6	34440	36736	40284	48633	50303	50720	52181	54269	54686	56356	58025	59069	62618	66166	68045	72845	75976	79525
7	35484	37780	41536	51138	52808	53225	54269	56356	56565	58234	60113	60949	64914	68670	70341	75350	78273	-
8	36318	38614	42580	-	-	54686	56356	58339	58443	60113	61783	62826	66896	71385	72949	-	-	-
9	37361	39658	43833	-	-	-	-	60216	61783	63244	64600	-	-	-	-	-	-	-
10	38405	40701	44876	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	39449	41745	46129	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	40493	42789	47173	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1999 оны 224 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсгалд

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИЙН

/саяд мянрагаар/

Цалингийн сүлжээний төрөл /ажлаалсын жүлээр/	Албан тушаалын зэрэглэл																	
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14				
1-4	24750	26813	28875	30938	33688	36438	39188	41938	44688	48125	51563	56375	61875	68750				
5-8	26125	28188	30250	32313	35159	38033	40783	43533	46283	49720	53295	57998	63250	70125				
9-12	27500	29563	31625	33688	36630	39628	42378	45128	47878	51315	55028	59620	64625	71500				
13-16	28875	30938	33000	35063	38101	41223	43973	46723	49473	52910	56760	61243	66000	72875				
17-20	30250	32313	34375	36438	39573	42818	45568	48318	51068	54505	58493	62865	67375	74250				
21-24	31625	33688	35750	37813	41044	44413	47163	49913	52663	56100	60225	64488	68750	75625				
25 ба түүнээс дээш	33000	35063	37125	39188	42625	46063	48813	51563	54313	57750	61875	66000	70125	77000				



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож, 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй:

Нийслэлийн дүүргийн Засаг дарга	56356-66793
Сумын Засаг дарга	52181-62618
Хорооны Засаг дарга	41745-50094
Багийн Засаг дарга	35484-43833

Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 153 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	Р.АМАРЖАРГАЛ
САНГИЙН САЙД	Я.ОЧИРСҮХ
ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Ан агнуурын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. 2000 онд тусгай төлбөртэйгээр агнуулах угалз 40, тэх 300, хар сүүлт зээр 60 хүртэл толгой байхаар тогтоосугай.

2. Тусгай төлбөртэйгээр ан амьтан агнуулснаас улсын төвлөрсөн төсөвт орох

орлогын зохих хувийг нэн ховор, ховор ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд зориулан зарцуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Байгаль орчны сайд С.Мэндсайхан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	Р.АМАРЖАРГАЛ
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД	С.МЭНДСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2000 оны 2 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 2000 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Төрийн ордны 251 дүгээр өрөөнд зөвлөлдөж гаргав.

Цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүд Ж.Болдбаатар, Ж.Бямбажав, Д.Дэмбэрэлцэрэн, В.Удвал /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүүг оролцуулан хийв.

Тус хуралдаанд маргагч /нэхэмжлэгч/ тал болох Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэн Ө.Сэргэлэн оролцов. Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Д.Хувьтөгөлдөр хуралдаанд ирээгүй болно.

Иргэн Ө.Сэргэлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд 1999 оны 12 дугаар сарын 17-нд гаргасан

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

өргөдөлдөө: "Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-д "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэж заажээ. Тухайн заалтад буй "гагцхүү шүүх" гэдэг нь шүүх байгууллага шүүх эрх мэдлийн хүрээнд ганцаараа эцсийн шийдвэр гаргана гэсэн утга агуулгыг илэрхийлж байна. Тэгвэл шүүх байгууллага болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий бусад субъектүүд болох прокурор, цагдаагийн байгууллагууд нь нэгдмэл нэг зорилгын хүрээнд бие даасан хараат бус байдалд үйл ажиллагаа явуулснаар ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлыг хангах, гагцхүү хуульд захирагдаж хуулийг дээдлэх боломж бүрдэх юм. Шүүх эрх мэдэл нь эрүү, иргэн, захиргааны хэргийг үүсгэх, хянан шийдвэрлэх, шүүн таслах гэсэн олон талт үйл ажиллагааны хүрээнд авч үзэх өргөн ойлголт юм.



Эрүүгийн процессын энэ бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч субъектүүдийн аль нэг нь зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрийн хувьд шүүх эрх мэдлээс ангид байхаар хуульчлагдах нь гэм бурууг тогтоох ажиллагааг хэрэгжүүлэх явцад хуульд захирагдахгүй байх, энэ утгаараа шүүх шударга шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа болно. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй субъектүүдийн тогтолцоог Үндсэн хууль, бусад хуулиар зохицуулжээ. "Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийг боловсруулж, батлан гаргахдаа төрийн эрх мэдэл хуваарилах Үндсэн хуулийн концепцийг умартан онол арга зүйн ноцтой алдаа гаргаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагыг бүтээц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрийн хувьд төрийн гүйцэтгэх эрх мэдлийн шууд хяналтан дор байхаар хуульчилсан нь шүүх эрх мэдэл нь гэм бурууг тогтоох эхний шатнаасаа, гүйцэтгэх эрх мэдлийн тодорхой албан тушаалтнуудын хууль бус ашиг сонирхолд нийцэж байхаас аргагүйд хүрэх, тэдний сонголт, томиллооор үйл ажиллагаа нь хөтөлгөдөн явах, улс төр, бизнесийн тодорхой бүлэглэлийн хүрээнд хууль үйлчлэхгүй байж болох эрх зүйн сөрөг орчинг бүрдүүлж, энэ нь коррупци, авилгалын гэмт хэрэг гарч нийгмийн бүхий л хүрээг хамарч байх ёстой зүйл, жирийн үзэгдэл мэт болтлоо өргөжиж, улс орныг мөхөлд ч хүргэж болох аюулыг нүүрлэж байна.

Иймд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-ийг зөрчиж буйг хянан үзэж шийдвэрлэж өгнө үү" гэжээ.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр Ө.Сэргэлэн гаргасан нэмэлт тайлбартаа: "Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий мөрдөн байцаах газрыг цагдаагийн байгууллагын системд оруулж, түүний удирдлагыг Засгийн газраас томилж байгаа нь Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-ийн "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" хэмээх заалтыг зөрчиж байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага цагдаагийн байгууллагын шууд бүтцэд багтах нь тохиромжгүй бөгөөд эдгээрийн удирдлагыг Засгийн газар томилж, өөрчлөх асуудлыг шийдэж байгаа нь Үндсэн хуулийн агуулгад нийцэхгүй байна" гэлээ.

ХЯНАВАЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны явцад нэхэмжлэгч Ө.Сэргэлэн өөрийн өргөдөл дэх "Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгтэй холбогдож гаргасан гомдлын шаардлагаасаа татгалзсан болно.

2. Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт буй "Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг Монгол Улсын Цагдаагийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-д буй "Засгийн газар Монгол Улсын хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг баталж, даргыг томилж, чөлөөлнө" гэсэн заалт зөрчсөн тухай үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-д буй "Засгийн газар Монгол Улсын хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг баталж, даргыг томилж, чөлөөлнө" хэмээх заалт Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт буй "Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

Ж.БОЛДБААТАР
Ж.БЯМБАЖАВ
Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН
В.УДВАЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

МАХН-ын архивын баримтыг ашиглуулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 7 дугаар тогтоолын 3 дугаар заалт, МАХН-ын нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. МАХН-ын архивын баримтыг ашиглуулах нийтлэг журмыг 1. төлбөрт үйлчилгээний үнийн

тарифийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг 2000 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн МАХН-ын төв, орон нутгийн архивуудад дагаж мөрдөхийг архивын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

САЙД

ДАШ.ГАНБОЛД

Хууль Зүйн Сайдын 2000 оны 18 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

МАХН-ЫН АРХИВЫН БАРИМТЫГ АШИГЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. МАХН-ын төв болон орон нутгийн архивын сан хөмрөгөөс судалгаа сурталчилгаа, албан ажлын хэрэгцээнд баримт бичиг ашиглуулах, байгууллага иргэдэд лавлагаа, хуулбар олгох, судлаачдад архивын уншлагын танхимаар үйлчлэхэд энэхүү журмыг баримтлана.

2. Намын архивын сан хөмрөгийн баримт бичгийг ашиглуулах үндсэн хэлбэрүүд нь:

а) байгууллага, иргэдэд архивын лавлагаа, хуулбар олгох

б) архивын уншлагын танхимаар дамжуулан судлаачдад уншуулах

в) хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах

г) гэрэл зураг, дуу авианы баримтыг хэсэгчлэн хуулбарлах.

3. Архивын баримт бичгийг гадаадын иргэд, судлаачдад ашиглуулахдаа МАХН-ын төв архивт МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нарын, орон нутгийн МАХН-ын архивуудад тухайн аймгийн намын хорооны даргын зөвшөөрлийг үндэслэн зөвхөн уншлагын танхимаар үйлчилнэ.

Архивын байгууллага иргэдэд лавлагаа, тодорхойлолт баримтын хуулбар олгоход дээрх заалт хамаарахгүй.

Тайлбар: МАХН-ын төв болон орон нутгийн намын байгууллагуудын албан ажлын хэрэгцээнд архивын баримт ашиглах тухайд "МАХН-ын Удирдах зөвлөлийн аппаратын архивын ажлын заавар"-ыг мөрдлөг болгоно.

4. Архив нь байгууллага, иргэдэд архивын лавлагаа, тодорхойлолт баримтын хуулбар олгох, судлаачдад уншлагын танхимаар үйлчлүүлэх зөвшөөрөл олгохдоо батлагдсан тарифын дагуу үйлчилгээний хураамж авна. Хураамжийг Үндэсний архивын газрын төсөвт оруулна.

5. Архивын баримт ашиглуулах тухай журмыг зөрчсөн архивын ажилтан, иргэд, хуулийн этгээдэд Архивын тухай Монгол улсын хууль болон архив албан хэрэг хөтөлөлтийн улсын хяналтын дүрэмд заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

Хоёр. МАХН-ын архивын баримтыг

уншлагын танхимаар ашиглуулах тухай

1. Архивт баримт бичиг судалж ашиглахыг хүсэгчид нь албан газрын бичиг буюу хувийн өргөдөл гаргаж баримт судлах албан ёсны зөвшөөрөл авна.

2. Намын төв архивын баримт бичгийг судлах зохих зөвшөөрөл бүхий хүн бүрд доорхи баримт бичгээс бүрдсэн хувийн хэргийг хөтөлнө.

Үүнд:

а) Баримт бичгийг ашиглуулах зөвшөөрөл

б) Судлаачийн анкет

в) Судлаачийн өргөдөл

г) Аль сан хөмрөгийн, ямар материал олгож ашиглуулсан тухай бүртгэл зэргийг хавсаргана.

3. Судлаач нарын судалгааны ажлын зорилго, сэдэв, хүрээг харгалзан 3 сар хүртэл хугацаагаар баримт судлах зөвшөөрлийг МАХН-ын архивын эрхлэгч олгох бөгөөд үйл ажиллагаанд нь МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нар байнга хяналт тавьж ажиллана.

4. Судлаач нь намын архивын баримт ашиглах энэхүү журам судлаачын хүлээх үүрэг /загвар-1/-тэй танилцсаны дараа судлаачийн анкет/загвар-2/ бөглөж хувийн хэрэг нээлгэнэ.

5. Судлаач нь уншлагын танхимын эрхлэгчийн зөвшөөрснөөр судлах сэдвийн дагуу архивын данс бүртгэлтэй танилцаж, судлах баримтын захиалгаа өгнө.

6. Уншлагын танхимын эрхлэгч нь судлаачаас захиалга хүлээн авснаас хойш нэг хоногийн дараа захиалсан хадгаламжийн нэгж, баримтыг бэлэн болгоно. Энэ хугацаанд захиалын хуудсанд бичигдсэн данс болон хадгаламжийн нэгжийн дугаарыг сан хөмрөгийн эрхлэгчээр тэмдэглүүлэн холбогдох баримтуудыг хуудас нэг бүрээр шалган хүлээн авах ба судлаачаас мөн адил шалган гарын үсэг зуруулан буцааж авна.

Судлаачдад нэг удаад 10-аас илүүгүй хадгаламжийн нэгж олгоно.

7. Уншлагын танхимаар үйлчлүүлэгчид нь судалгаанд олгосон хадгаламжийн нэгж бүрт ашиглалтын хуудас хөтлөх /загвар-3/ ба тухайн баримтыг ашигласан тохиолдолд өөрийн ном бүтээлдээ ишлэл зүүлт хийнэ.

8. Судлаач нь зөвхөн өргөдөл, хүсэлтэд дурьдсаны дагуу холбогдох сэдэв, асуудлын

хүрээнд хамаарах баримтыг судлах ба архивын баримттай ажиллах явцад хийсэн тэмдэглэлийг уншлагын танхимын эрхлэгч, архивын холбогдох ажилтнуудад шалгуулж, архивын үйлчилгээтэй холбогдсон санал хүсэлтээ удирдлагад тавьж болно.

9. Нэн үнэт, ховор нандин баримтыг судлаачдад зөвхөн хуулбараар ашиглуулна.

10. Гадаадын судлаачдад зөвхөн сонирхсон сэдэв, асуудлын хүрээнд оноосон баримт бичиг үзүүлэх ба агуулга нь тодорхойгүй олон янзын баримтаас бүрдсэн хадгаламжийн нэгжийг бүхлээр

нь буюу нэг дор олноор нь ашиглуулахыг хориглоно.

11. Баримт бичгийг нугалах, бохирдуулах, засварлах, урж гэмтээх, ил задгай орхих, зөвшөөрөлгүй гадагш нь авч явах ба бусдад дамжуулах зэргээр архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын журмыг ноцтойгоор зөрчөл дээрх зөрчлийг гаргасан иргэдээр хохирлыг нөхөн төлүүлж, архивт сууж ажиллах эрхийг хасаж болно.

12. Судлаач нь уншлагын танхимд бичгийн сав, зургийн болон хувилах аппарат, хүнсний зүйл биедээ авч орохыг хориглоно.

Затвар 1

СУДЛААЧИЙН ҮҮРЭГ

1. Судлаачид баримт бичиг ашиглахдаа доор дурдсан үүргийг хүлээнэ.

а) баримт бичгийг цэвэр гамтай ашиглах;

б) судалгааны сэдэвтээ холбогдолгүй зүйлсийг бичиж тэмдэглэхгүй байх

в) архивын баримт бичгээс тэмдэглэж ашиглахдаа уул баримт бичгийн фондын, данс, хадгаламжийн нэгжийн хуудасны дугаарыг үнэн зөв бичих;

г) баримт бичгийг судалж үзсэний дараа хадгаламжийн нэгжийн ашиглалтын хуудсанд юуны тухай хэддүгээр хуудаснаас тэмдэглэл хийснээ заавал товч бичиж байх;

д) архивын баримтыг судлах явцад хийсэн тэмдэглэлээ уншлагын танхимын эрхлэгчид шалгуулна. Баримт бичгийг бүхэлд нь хуулан авахыг зөвшөөрөхгүй.

2. Судлаачдаас баримт бичгийг ашиглаж

байх үед хориглох зүйл:

а) уншлагын танхимд тамхи татах;

б) баримт бичгүүдийг нугалах, бохирдуулах, засварлах, урж гэмтээх, ил задгай орхих, зөвшөөрөлгүй гадагш авч явах ба бусдад дамжуулах;

в) бичгийн сав, зургийн болон хувилах аппарат, хүнсний зүйл биедээ авч уншлагын танхимд орох.

Энэхүү үүргийг зөрчсөн судлаачдад цаашид баримт бичиг ашиглуулахыг зогсоож архивт учруулсан хохиролыг барагдуулж, хариуцлага хүлээлгэнэ.

УНШИЖ ТАНИЛЦСАН

()

УНШЛАГЫН ТАХНИМЫН ЭРХЭЛЭГЧ

()

Затвар 2

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН АРХИВ СУДЛААЧИЙН АНКЕТ

Хувийн хэргийн дугаар

6. Судалгаа хийх хугацаа /он, сар, өдөр/

.....

1. Овог нэр.....

7. Албан ажлын болон гэрийн хаяг, утасны дугаар

.....

2. Хаана, ямар ажилтай

3. Боловсрол, эрдмийн зэрэг цол, бусад цол

8. Үнэмлэх, паспортын дугаар

.....

4. Аль байгууллагын томилолтоор, судалгааны зорилго.....

Баримт бичиг ашиглах журмыг чанд мөрдөж ажиллахаа батална.

СУДЛААЧИЙН ГАРЫН ҮСЭГ

5. Судалгааны сэдэв, он цагийн хязгаар.....

Улаанбаатар хот он ... сар ... өдөр



Загвар 3

..... -Р САН ХӨМРӨГИЙН -Р ДАНСНЫ
.....-Р ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН АШИГЛАЛТЫН
ХУУДАС

д/д	Он,сар, өдөр	Судалгааны сэдэв	Хуудас- ны дугаар	Судлаачийн овог, нэр / татлахгүй, гарцагтай бичнэ/

Хууль Зүйн Сайдын 2000 оны 18
тоот тушаалын 2 дугаар хэсгээр

МАХН-ЫН АРХИВААС ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ

Нэг. Удирдлагын болон түүхэн баримтыг ашиглуулах үйлчилгээний хураамж

1. Үйлчилгээний төлбөр 100 төгрөгийг лавлагаа хүүсэн өрөгдлийн хамт хүлээн авна.
2. Тогтоол, тушаал зэрэг эрх зүйн баримтын хуулбар, лавлагаа-700 төг
3. Тоо бүртгэлийн баримтаас овог, нэр, нас, түүх намтрыг тодруулах нэг лавлагаа-1500 төгрөг
4. Цалингийн тодорхойлолт нэг оных - 150 төгрөг
5. Архивт суух судлаачдад үзэх баримт бичгийн жагсаалтыг архивын ажилтнууд бэлтгэж өгөх (нэг оных)-500 төгрөг
6. Гадаадын судлаачдад сонирхсон сэдэв, асуудлын нь дагуу уншиж танилцах баримт бичгийн жагсаалтыг архивын ажилтнууд бэлтгэж өгвөл - 5 ам.доллар (нэг оных)
7. Гадаадын судлаач архивын баримт бичгийн данс бүртгэл, карт каталог ашиглаж судлавал - 5 ам.доллар
8. Судлаачид архивын баримт бичгийн данс бүртгэл,

карт каталог лавлагааны бусад материалыг ашиглах, судлах (нэг удаа) - 800 төгрөг
 9. Уйгаржин монгол үсгээр бичигдсэн баримт бичгийг кирилл үсгээр буулгаж бичих, 1 хуудас - 250 төгрөг
 10. Архивын сан хөмрөгөөс сэдэвчилсэн танилцуулга бичих нэг хуудас нь 600 төгрөг
 11. Судалгаа, эрдэм шинжилгээний ажлын зориулалтаар баримтын хуулбар олгох.

Он цаг	Дотоодын судалгааны үнэлгээ(төгрөгөөр)	Гадаадын судалгааны үнэлгээ(ам.доллар)
1.1920-1950	1 хуудас 4000	10
2.1951 оноос хойш	1 хуудас 1000	5

12. Намын төв архивын уншлагын танхимаар үйлчлүүлэхэд:

- а) Байгууллагын шугамаар ирж ажиллаж байгаа бол -3000 төг
- б) Хувиараа судалгаа хийх бол 2000 төгрөг
- в) Гадаадын иргэд - 50 ам.доллар

Хоёр. Гэрэл зургийн баримт материалыг ашиглуулах үйлчилгээний хураамж

1. Гэрэл зургийн баримтыг ашиглуулах үйлчилгээний үнэ тариф:

оны хязгаар	9 x 12	13 x 18	18 x 24	24 x 30	30 x 40
1900-1921	1000	1150	1300	1450	1600
1922-1938	910	1060	1200	1360	1530
1939-1946	800	970	1180	1240	1420
1947-1960	730	880	1030	1180	1330
1961-1980	640	790	940	1090	1240
1981-1990	550	700	850	1000	1150
1990 оноос хойш	460	610	760	810	1060

2. Гадаадын иргэдэд гэрэл зургийн баримтыг ашиглуулах үйлчилгээний үнэ тариф (ам. доллараар)

оны хязгаар	9 x 12	13 x 18	18 x 24	24 x 30
1900-1921	15	17	19	21
1922-1938	13	15	17	19
1939-1946	11	13	15	17
1947-1960	9	11	13	15
1961-1980	7	9	11	15
1981-1990	5	7	9	11
1990 оноос хойш	4	5	7	9

Тайлбар: гэрэл зургийн материалын ашиглалтын чиглэл, чанарыг харгалзан тухайн үед 30-50%-ийн хөнгөлөлт үзүүлж болно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2000 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 154/201

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 52 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны мэдээллийн төв санг бүрдүүлэх журмын 20 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Байгаль орчны мэдээллийн төв санд бүрдүүлсэн мэдээг ашиглуулах, түгээх, орлого бүрдүүлэх, түүний орлогыг захиран зарцуулах

журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдүүлж ажиллахыг мэдээллийн төв сангийн захирагч Д.Баасандоржид даалгасугай

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД С.МЭНДСАЙХАН

САНГИЙН САЙД Я.ОЧИРСҮХ

Байгаль орчны сайд, Сангийн сайдын 1999 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 154/201 тоот хамтарсан тушаалын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ САНГИЙН МЭДЭЭГ АШИГЛУУЛАХ, ТҮГЭЭХ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ, ОРЛОГЫГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1 Байгаль орчны мэдээллийн төв санд /цаашид сан гэх/ бүрдүүлсэн мэдээ зураг баримт, тайлан, зохиогчийн эрхэд хамаарсан бүтээл зэргийг /цаашид мэдээ баримт гэх/ үнэлэх, ашиглуулах хэрэглэгчдэд түгээх, мэдээллийн сангийн орлого бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулахад энэхүү журмыг даган мөрдөнө.

1.2 Сангийн үйл ажиллагааг хариуцагч байгууллага, албан тушаалтан тухайн жилийн орлого, зарлагын төлөвлөгөөний төслийг "Төсвийн тухай хууль"-д заасан хугацаанд холбогдох танилцуулга тооцооны хамт, Сангийн яаманд хүргүүлж, Монгол Улсын төвлөрсөн төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайланд тусгуулж байна.

Хоёр. Байгаль орчны мэдээллийн төв сангийн захирагчийн эрх үүрэг.

2.1 Байгаль орчны мэдээллийн төв санд бүрдүүлсэн орлогыг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан/ цаашид захирагч гэх/ -г Мэдээллийн төв санг бүрдүүлэх журмын 3 дугаар зүйлийн 23 дугаар заалтын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилно.

2.2 Захирагч нь хэрэглэгчдийн шаардлага сонирхолд нийцүүлэн мэдээг ашиглуулах үйл ажиллагааг зохион байгуулах, үр ашгийг нь дээшлүүлэх, сурталчлах, хэрэглэгчдийн хүрээг өргөтгөх,

мэдээг шинэчлэх өөрчлөх, нууцлах, хадгалах, архивлах, ашиглуулах, худалдах, худалдан авах зөвшөөрөл олгох, орлогыг захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхтэй.

2.3 Захирагч нь тус сангийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлт хийх, мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөл олгох зэрэг асуудлаар шийдвэр гаргана.

2.4 Захирагч нь мэдээлэл боловсруулахад шаардлагатай баримт бичиг, үйлдэх, анхдагч бүртгэл хөтлөх, үнэн зөв мэдээлэл гаргаж хэрэглэгчдийг хангах талаар зөвлөгөө өгөх, захирамж гаргах эрхтэй болно.

2.5 Сангийн захирагч нь албан үйл ажиллагаандаа Байгаль орчны яамны албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдгийг хэрэглэж болно.

2.6 Мэдээллийн төв сангийн үйлчилгээний төлбөр, хураамжийг шилжүүлгээр болон бэлнээр авч, орлогыг хуримтлуулах бөгөөд санхүүжилтын ажлын зарлага, гүйлгээг Сангийн яамны зөвшөөрлөөр банкны байгууллагад нээсэн тусгай харилцах дансаар хийж гүйцэтгэнэ.

2.7 Санд бүрдүүлсэн мэдээг үнэлэх, ашиглуулах, үйлчилгээний үнийн төслийг боловсруулах шалгуурыг зохиох үүрэг бүхий мэдээллийн магадлан шалгах зөвлөлийг захирагчийн санал болгосноор байгаль орчны

асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн томилно.

2.8 Магадлан шалгах зөвлөлийн гишүүдэд хагас болон жилийн эцэст тухайн гишүүдийн ажлын үр дүнг үндэслэн, захирагчийн шийдвэрээр мэдээллийн төв сангийн орлогоос зохих хэмжээний мөнгөн урамшуулалыг олгож болно.

Гурав. Мэдээллийн төв санд бүрдүүлсэн мэдээг ашиглуулах, түгээх үйл ажиллагаа.

3.1 Мэдээллийн төв санд бүрдүүлсэн байгаль орчин, экологийн эрхзүйн тусгай объектууд /газар, газрын хэвлийн, түүний нөөц баялаг, ой, ус, амьтан, ургамал, агаар, хөрс / тэдгээрийн холбогдолтой бүх төрлийн мэдээ, мэдээлэл төрийн өмч байна.

3.2 Мэдээллийн төв санд бүрдүүлсэн мэдээ, мэдээлэл, баримт, зураг, зохиогчийн эрхэд хамаарах бүтээл зэрэг сангийн өмчийг Мэдээлэл тооцооллын төв, тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтан захирагчийн зөвшөөрлөөр зориулалтын дагуу баяжуулан шинэчлэх, ашиглуулах, хамгаалах, нууцлалыг хадгалах үүрэг хүлээнэ.

3.3 Мэдээний ашиглалтын талаар мэдээллийн санг хариуцагч нь хэрэглэгчидтэй гэрээ хийж, энэхүү журамд дурьдсан хариуцлагыг харилцан хүлээх талаар тохиролцоно.

3.4 Мэдээгээр үйлчлүүлэгчид, хэрэглэгчид нь мэдээний бүрэн бүтэн байдал, хадгалалт, нууцлалыг хариуцахаас гадна уг мэдээг агуулсан файл, диск, зураг, тайлан зэргийг бусдад дамжуулах, худалдах өөрчлөх, хувиан олшруулах, зохиогчийн эрхийг хөндөх зэргээр ашиглахыг хориглоно.

3.5 Мэдээг бүтээл туурвих, судалгаа сурталчилгаа хийх зорилгоор ашиглахдаа ашиглагч нь уг мэдээгээр үйлчилсэн мэдээллийн сангийн нэр, хаяг, мэдээ эзэмшигчийн нэрийг заавал ишлэл авч байна.

3.6 Мэдээг ашиглагч нь эх мэдээний зохиогчийн гаргасан гол утга санааг өөрчлөхгүйгээр шинэ мэдээгээр баяжуулан, дүн шинжилгээ хийх үүднээс боловсруулалт хийж засварлан хэрэгжүүлж болно.

3.7 Мэдээг дараах тохиолдолд үнэ төлбөргүй ашиглуулна.

3.7.1 Улсын болон хүн амын аюулгүй байдалтай холбоотой, улс орны чухал ач холбогдолтой стратегийн чухал асуудлыг шийдэх, Засгийн газрын үндсэн үүрэг болон олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах байгаль цаг уурын онц аюултай өөрчлөлт, байгалийн

гамшгийн мэдээгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэ төлбөргүй үйлчилнэ.

3.7.2 Төрийн захиргааны болон тэдгээрийн харьяа байгууллагууд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургуулиуд, коллежууд зэрэг төсвийн болон улс орны нийгэм эдийн засаг байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа байгууллагуудад улсын төсвөөр бүрдүүлсэн мэдээлэлээр үнэ төлбөргүй үйлчилнэ.

3.8 Байгаль орчны болон "БОХ" маягтын статистик мэдээллийг албан ёсны бус хэрэгцээнд авч ашиглагч нь мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.

Дөрөв. Мэдээллийн сангийн мэдээг үнэлэх, орлогыг бүрдүүлэх, зарцуулах.

4.1 Мэдээг холбогдох хуулиуд болон төв санг бүрдүүлэх журмын 20 дугаар заалтын дагуу тус сангийн мэдээ баримтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахын тулд мэдээний ач холбогдлоос хамааран үнийг ялгаатай тогтооно.

4.1.1 Мэдээний тойм үнийн дээд, доод хязгаарыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлана.

4.1.2 Судалгаа шинжилгээний буюу нарийн дүн шинжилгээ хийж боловсруулагдсан, чухал ач холбогдолтой мэдээг түүнийг боловсруулахад гаргасан зардал, хугацаа өртгийг харгалзан энэхүү журмын 2.7 дугаар заалтын дагуу магадлан шалгах зөвлөлийн гаргасан санал дүгнэлтийг үндэслэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хязгаарт багтаан үнэ тогтооно.

4.1.3 Зохиогчийн эрхэд хамаарах мэдээ болон бүтээлийн үнийг тогтоохдоо, магадлан шалгах зөвлөл зохиогчтой зөвшилцөж гаргасан үнийн саналыг Байгаль орчны сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батална.

4.1.4 Төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллага, түүнчлэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн байгаль орчны холбогдолтой судалгаа шинжилгээний ажлын тайлан, мэдээ, баримт, зураг бүртгэл тооцоо, бүтээл зэргийг мэдээллийн санд үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бүртгэсний дараа мэдээллийн төрлөөр ялган үнэ тогтооно.

4.1.5 Мэдээ баримт ашиглуулсаны төлбөр нь мэдээг ямар зориулалтаар ашиглаж байгаа болон, эрэлт хэрэгцээ, шаардлагаас хамаарч уян хатан



байж болох бөгөөд жил бүр өөрчлөлт хийж болно.

4.2 Мэдээллийн сангийн орлого нь байгаль орчны холбогдолтой мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хангах, мэдээг судалгаа шинжилгээ явуулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ өгөх, төсөл боловсруулах ажилд ашиглуулах үйлчлэгээний төлбөрийн орлогоос бүрдэнэ.

4.3 Байгаль орчны мэдээллийн төв санд орлого хуримтлуулах эх үүсвэр, орлогын хэмжээг харгалзан сангийн орлогоос тухайн жилд зарцуулах, ашиглах хөрөнгийн хэмжээг зориулалт тус бүрээр нь сан хариуцагч гаргах бөгөөд уг төсвийг сангийн яамтай зөвшилцөн Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.4 Санд хуримтлуулсан орлогын хэмжээгээс хамааран мэдээллийн төв санд мэдээ бүрдүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлыг нөхөн санхүүжүүлж, үлдэх хэсгийг уг журамд заасан зориулалтаар зарцуулж болно.

4.5 Сангийн үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, мөрдүүлэх бөгөөд уг үйлчилгээгээс олсон орлогоос байгаль орчны мэдээллийн төв санд бүрдүүлэх мэдээ, зураг, баримтыг худалдан авахад зарцуулж болно.

4.6 Мэдээллийн сангийн мэдээ мэдээллийн ашиглалт, үйлчилгээгээс олсон орлогыг дараахь үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

4.6.1 Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний талаарх төсвийн бус хөрөнгөөр буй болсон шаардлагатай чухал мэдээг худалдан авах,

4.6.2 Нэн чухал зурган болон ховор мэдээг сэргээн засварлах, шинээр олшруулах, хувилах, хэвлэх, шинэчлэх,

4.6.3 Программ хангамж, техник, технологийг сайжруулах мэдээ мэдээллийг найдвартай хадгалах, зөвөөрлөх, дамжуулах, нууцлах зориулалтын техник хэрэгслийг худалдан авах, суурилуулах, засвар үйлчилгээний төлбөрийг төлөх,

4.6.4 Байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал өөрчлөлтийн байдлыг судлан тогтооход шаардлагатай мэдээллийг

цуглуулах, боловсруулалт дүгнэлт шийдэл гаргах чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

4.6.5 Байгаль орчны төв мэдээллийн санд мэдээ бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ховор мэдээ, зураг бүрдүүлж өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;

4.6.6 Экологийн боловсрол, мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.6.7 Байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбогдсон семинар, сургалт, уулзалт, хурал зохион байгуулах, орон нутгийн мэдээллийн дэд сангуудын үйл ажиллагааг дэмжих,

4.6.8 Байгаль орчны мэдээллээр үйлчилгээ явуулах, мэдээллийн эмхтгэл, танилцуулга, сангийн бусад баримт бичгийг хэвлэн нийтлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх

4.6.9 Иргэн, төрийн өмчийн бус, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн буюу улсын захиалга, олон улсын байгууллага, гадаад орны тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний ажлын тайлан, зураг, төсөл, байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн талаархи мэдээг, мэдээллийн төв санд болон тухайн асуудалд хамаарах дэд, төрөлжсөн дэд сангуудад Төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Засаг даргын тамгын газар, экспертийн зөвлөлийн санал дүгнэлт болон сангийн захирагчийн зөвшөөрлөөр, зохих үнэ төлбөртэйгээр хүлээн авна.

Бусад зүйл

5. Байгаль орчны мэдээллийн төв сангийн орлогын зарцуулалтын үйл ажиллагаанд тус яамны төрийн захиргаа, үнэлгээ мэдээллийн газар хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гарган үнэлгээ өгч, төв сангийн захирагч ерөнхийд нь хяналт тавина.

6. Сангийн орлогыг төвлөрүүлж байгаа байгууллага буюу хариуцсан албан тушаалтан, сангийн орлогоос захирагчийн зөвшөөрөлгүй дур мэдэн зарцуулахыг хориглоно.

7. Захирагч нь мэдээллийн төв сангийн орлогыг энэхүү журамд заагдаагүй буюу зориулалтын бус зүйд зарцуулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гарган.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☐ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☐ 329487